



Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн  
2020 оны 08 сарын 11 ний өдрийн  
12 дугаар тогтоолын хавсралт

ЭМГЭГ СУДЛАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТЭН

*Баярсанаа*  
Э.БАЯРМАА

### АНАТОМИЙН ЭМГЭГ СУДЛААЧ ЭМЧ

**АХЛАХ** зэрэг горилогч анатомийн эмгэг судлаач эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна.Үүнд

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/мэргэжлийн чиглэлийн багц сургалтанд жил бүр хамрагдсан байна(сертификатаар баталгаажуулна).
2. Эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож 3-аас цөөнгүй бүтээлийг нийтлүүлсэн байна.( Өөрөө болон бусад эмч настай хамтран оношилсон ховор тохиолдол-1-2, судалгааны илтгэл -2 гм) тус бүр мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна.
3. Мэс заслын эмгэг, дуран, эмэгтэйчүүдийн амьд сорьцын хавдар болон хавдрын урьдал эмгэг яланг оношлох чадвар эзэмшсэн байна
4. Эмгэг судлалын оношлоход төвөгтэй тохиолдлыг дотоод, гадаадын эх сурвалжаас олж мэдэх, оношлох, дүгнэх мэдлэг чадвартай байх
5. Тухайн мэргэжлээрээ тасралтгүй 8 жил ажиллаж, сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайланг бичгээр илгээх.

**ТЭРГҮҮЛЭХ** зэрэг горилогч анатомийн эмгэг судлаач эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна .Үүнд

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/мэргэжлийн чиглэлийн багц сургалтанд жил бүр хамрагдсан байна.
2. Эрдэм шинжилгээний судалгааны ажил хийж, сүүлийн 5 жилд 5-аас цөөнгүй бүтээлийг хэвлэн нийтлүүлсэн байна. (Өөрөө болон бусад эмч настай хамтран оношилсон ховор тохиолдол- 2 оос дээш, эрдэм шинжилгээний илтгэл -2, нэгдүгээр зохиогчоор судалгааны өгүүлэл- 1) тус бүрийг мэргэжлийн сэтгүүлд хэвлэн нийтлүүлсэн байна.

3. Анатомийн эмгэг судлаач залуу эмч нар, ахлах зэрэгтэй эмч наарт зөвөлгөө өгөх, мэргэжил, арга зүйгээр хангах чадвар эзэмшсэн байх
4. Бүх төрлийн хорт хавдрыг ялган оношилж, олон улсын ангиллаар бие дааж үнэлэх, дүгнэх чадвартай байх
6. Эмгэг судлалын шинжлэх ухааны шинэ технологи, инновацид суралцсан байх (ИГХ ийн будаг/биомаркерийн үр дүнг үнэлэх чадвар эзэмшсэн байх)
7. Ахлах зэрэг хамгаалснаас хойш мэргэжлээрээ тасралтгүй 5 жил ажилласан, сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайланг бичгээр өгөх.
8. Төгсөлтийн дараах сургалтын эмгэг судлалын сургагч багшаар ажиллаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэж, дагалдан болон шавилан сургасан байх.
9. Магистрын зэрэг хамгаалсан бол давуу тал болно.

**ЗӨВЛӨХ** зэрэг горилогч анатомийн эмгэг судлаач эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна .Үүнд:

1. Мэргэжлээрээ тасралтгүй 25-аас дээш жил ажилласан байх.
2. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэжлийн чиглэлийн багц сургалтанд жил бүр хамрагдсан байна.
3. Эмгэг судлалын сургагч багшаар ажиллаж, АУ-ны магистр, клиникийн профессор цолтой байх.
4. Эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлыг удирдах болон төслийн багт хамтран ажилласан, сүүлийн 5 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээл мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх (дотоодод 2 өгүүлэл, гадаадад-1 өгүүлэл, нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх орж болно).
5. Эмгэг судлалын шинжлэх ухааны оношлогооны шинэ арга, технологиос практикт нэвтрүүлэх, мэргэжлийн чиглэлээр оношлогооны бичиг баримт боловсруулах чадвартай (эмгэг судлалын заавар, удирдамж, стандарт зэргийг боловсруулах багийг удирдсан, эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, ИГХ ийн будаг /биомаркерийн үр дүнг үнэлэх чадвар эзэмшсэн байх)
6. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайлан бичгээр өгөх.
7. Анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан бол давуу тал болно.